



ИНД-12

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Осол, зөрчил болон статистик мэдээлэл

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-12 нь дараах үйл ажиллагааны шаардлагыг тогтооно:

- осол, зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах;
- осол, эсхүл ноцтой зөрчлийн дараа агаарын хөлөг, түүний бүрдэл, ачаа болон агаарын хөлгийн бүртгэлийг хамгаалалтад авах;
- агаарын хөлгийн үйл ажиллагааны болон статистикийн өгөгдөхүүнийг мэдээлэх.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-12-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-12, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 01 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2002 оны 09 сарын 17

Нэмэлт, өөрчлөлт 2

2010 оны 03 сарын 26

Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-12-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 12 A.10-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг — Ерөнхий зүйл	5
12.1. Зорилго	5
12.3. Тодорхойлолт	5
В Бүлэг — Хэрэг явдлыг мэдэгдэх, шинжлэн шалгах болон тайлагнах	7
12.51. Ослыг мэдэгдэх	7
12.53. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл.....	8
12.55. Зөрчлийг мэдэгдэх	8
12.57. Зөрчлийн дэлгэрэнгүй.....	10
12.59. Шинжлэн шалгах, тайлагнах.....	10
12.61. Мэдээлэл хүргүүлсэн этгээдийг нууцлах	11
12.63. Шийтгэлээс ангид байх	11
С Бүлэг — Агаарын хөлөг, түүнд агуулагдсан эд зүйлс болон бүртгэлийг битүүмжлэх.....	11
12.101. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх	11
12.103. Бүртгэлийг битүүмжлэх.....	12
12.105. Гэмтэлтэй бүтээгдэхүүн, бүрдэл хэсгийг хадгалах	12
Д Бүлэг — Статистик мэдээ	13
12.151. Агаарын хөлгийн үйл ажиллагааны статистик мэдээ	13
12.153. Статистикийн тайлангийн нууцлал	14
Хавсралт А — Зөрчлийн анхны мэдэгдэлд шаардагдах мэдээлэл.....	15

А Бүлэг — Ерөнхий зүйл

12.1. Зорилго

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:

- (1) осол, зөрчлийн талаар мэдэгдэх, шинжлэн шалгах, тайлагнах;
- (2) осол, эсхүл ноцтой зөрчлийн дараа агаарын хөлөг, агаарын хөлөгт агуулагдсан эд зүйлс болон агаарын хөлгийн бүртгэлийг хамгаалалтад авах;
- (3) осол, байгууламжийн алдааны зөрчил, агаарын зайн зөрчил, эсхүл түгээгдсэн мэдээллийн зөрчлийн бүртгэлийг хамгаалалтад авах;
- (4) агаарын хөлгийн үйл ажиллагааны болон статистик өгөгдөхүүнийг мэдээлэх.

(b) Энэ Дүрэм нь хууль болон ИНД-115-ийн дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд хийгдээгүй дараах үйл ажиллагаатай холбоотой зөрчилд хамаарахгүй:

- (1) ИНД-101 болон ИНД-102 пуужин, цаасан шувуу, хүнгүй агаарын хөлөг, жироглайдер, парасэйлийн;
- (2) ИНД-103 - микролайт агаарын хөлгийн;
- (3) ИНД-104 - глайдерын;
- (4) ИНД-105 - шүхрийн;
- (5) ИНД-106 - ханг-глайдерын.

12.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

Агаарын зайн зөрчил гэж дараах дүрэм, эсхүл журамд хайнга хандах, эсхүл тэдгээрийг мөрдөөгүйтэй холбоотой гарсан зөрчлийг:

- (1) агаарын хөлгүүд хоорондоо мөргөлдөхөөс зайлсхийх; эсхүл
- (2) агаарын хөлөг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээгээр хангагдаж байхдаа агаарын хөлгүүд хоорондоо болон бусад саадтай мөргөлдөхөөс зайлсхийх;

Агаарын хөлгийн зөрчил гэж өөрөөр ангилагдаагүй бол, агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчлийг;

Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил гэж зохицуулалттай агаарын ачааны байгууллага, эсхүл Агаарын тээвэрлэгчийн олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлөгт агаараар тээвэрлэхээр хүлээн авсан, эсхүл тээвэрлэсэн ачаа, эсхүл шуудантай холбоотой дараах зөрчлийг:

- (1) ачаа, эсхүл шууданд гэмтэл учруулсан, эсхүл гэмтэл учруулсан байж болзошгүй нь хууль бус үйлдэл хийгдсэн, эсхүл завдсаныг нотлох баримт байгаа;

- (2) ачаа, эсхүл шууданд хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодис илэрсэн;

Аэродромын зөрчил гэж агаарын хөлгийн үйл ажиллагаа болон дараах нөхцөлөөс үүссэн зөрчлийг:

- (1) аэродромын үйл ажиллагааны бүс дээрх, эсхүл аэродромын саадыг хязгаарлах гадаргууг хүрээлсэн саад; эсхүл
- (2) гэмтэлтэй ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ; эсхүл
- (3) маневрын талбайн гэмтэлтэй гадаргуу; эсхүл
- (4) аэродромын гэмтэлтэй бусад байгууламж;

Аюулгүйн хамгаалалтын зөрчил гэж хууль бус үйлдэлтэй холбоотой зөрчлийг;

Аюултай барааны зөрчил гэж агаарын тээвэрлэгч хүлээн авсны дараа агаараар аюултай барааг тээвэрлэхтэй холбоотой гарсан дараах зөрчлийг:

- (1) этгээдэд гэмтэл учруулсан, өмч хөрөнгө гэмтсэн, шатсан, хагарсан, асгарсан, шингэн шүүрсэн, эсхүл төөнөсөн, эсхүл сав баглааны бүрэн бүтэн байдлыг хадгалаагүй бусад нотолгоо; эсхүл
- (2) аюултай барааг буруу мэдүүлсэн, савласан, шошгожуулсан, тэмдэглэсэн, эсхүл баримтжуулсан;

Байгууламжийн алдааны зөрчил гэж нисэхийн байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой зөрчлийг;

Гэмтлийн зөрчил гэж нислэгт, эсхүл газарт илэрсэн, агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсгийн татгалзал, эсхүл дутагдалтай холбоотой зөрчлийг;

Мөрдөн шалгах гэж хууль зөрчсөн үйлдэл гарсан эсэхийг тогтоохоор хийгдэж буй шалгах ажиллагааг;

Ноцтой зөрчил гэж осолд хүргэх дөхсөн аливаа зөрчлийг (Ослын тодорхойлолт болон ноцтой зөрчлийн жагсаалт АС 12-1-д тусгагдсан);

Түгээгдсэн мэдээллийн зөрчил гэж нисэхийн мэдээллийн эмхтгэл, газрын зураг, схем зураг, эсхүл бусад хэлбэрээр агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан түгээгдсэн ноцтой алдаатай, бүрэн бус, эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөхүүнтэй холбоотой зөрчлийг;

Тээвэрлэж буй ачаа гэж нэг байрлалаас нөгөө байрлалд буулгах зорилгоор агаарын хөлгөөр тээвэрлэж байгаа аливаа өмч хөрөнгийг;

Үхлийн аюултай гэмтэл гэж ослоос хойш 30 хоногийн дотор үхэлд хүргэсэн гэмтлийг;

Хүнд гэмтэл гэж ослын улмаас хүнд учирсан дараах аливаа гэмтлийг:

- (1) гэмтэл авснаас хойш 7 хоногийн дотор, 48 цагаас дээш хугацаагаар эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай; эсхүл

- (2) хөл, гарын хуруу, эсхүл хамрын ясны жижиг хугарлаас бусад аливаа ясны хугаралд хүргэсэн; эсхүл
- (3) биеийн гэмтлээс шалтгаалан цус ихээр алдах, мэдрэлийн судас, булчин, эсхүл шөрмөс хүндээр гэмтэх; эсхүл
- (4) дотоод эрхтний гэмтэл; эсхүл
- (5) II, эсхүл III зэргийн түлэгдэлт, эсхүл их биеийн гадаргуугийн 5%-аас дээш хэсгийн аливаа түлэгдэлт; эсхүл
- (6) халдварт бодис, эсхүл туяанд төөнөгдсөн болох нь тогтоогдсон;

Хэрэг явдал гэж осол, эсхүл зөрчлийг;

Шувуутай холбоотой зөрчил гэж:

- (1) агаарын хөлөг нэг, эсхүл хэд хэдэн шувуутай мөргөлдсөн; эсхүл
- (2) нэг, эсхүл хэд хэдэн шувуу агаарын хөлөгт хэт ойртсоны улмаас нисгэгчид түгшүүр төрүүлэх шалтгаан болсон зөрчлийг тус тус ойлгоно;

ОЗШШБ гэж Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, Хавсралт 13-ын дагуу Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах байгууллагыг ойлгоно.

В Бүлэг — Хэрэг явдлыг мэдэгдэх, шинжлэн шалгах болон тайлагнах

12.51. Ослыг мэдэгдэх

(a) Осолд өртсөн агаарын хөлгийн дарга, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн, эсхүл агаарын хөлөг алга болсон тохиолдолд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь ослын талаар ОЗШШБ болон Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)-т цаг алдалгүй мэдээлнэ.

(b) Энэ зүйлийн (a)-ын дагуух мэдэгдэл нь ИНЕГ хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр байх ба тодруулах боломжтой бол, дараах мэдээллийг агуулсан байна:

- (1) тухайн осол болсон өдөр, цаг;
- (2) тухайн ослын шинж байдал;
- (3) тухайн агаарын хөлгийн маяг, бүртгэгч улс, бүртгэлийн дугаар;
- (4) тухайн агаарын хөлгийг эзэмшигч болон үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;
- (5) хялбар тодорхойлогдох газарзүйн цэгээр илэрхийлсэн агаарын хөлгийн байршил, эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан байршлын мэдээлэл;
- (6) тухайн агаарын хөлгийн даргын нэр;
- (7) үйл ажиллагааны төрөл;
- (8) тухайн агаарын хөлгийн нисэн гарсан сүүлчийн цэг;
- (9) тухайн агаарын хөлөг буулт үйлдэхээр зорьсон дараагийн цэг;

- (10) тэнгэрийн байдал, хур тунадас, салхины хурд болон алсын барааны харагдацын талаарх тайлбар;
- (11) тухайн агаарын хөлгийн бүхээгт байсан хүмүүсийн тоо;
- (12) тухайн ослын улмаас амь үрэгдсэн, эсхүл хүндээр гэмтсэн зорчигч болон багийн гишүүний тоо;
- (13) тухайн ослын улмаас амь үрэгдсэн, эсхүл хүндээр гэмтсэн, зорчигч, эсхүл багийн гишүүнээс бусад хүмүүсийн тоо;
- (14) тухайн агаарын хөлгийн гэмтлийн дэлгэрэнгүй.

12.53. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл

(а) Осолд өртсөн тухайн агаарын хөлгийн дарга, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн ослын талаарх СА005 маягтад шаардсан дэлгэрэнгүйг осол гарснаас хойш 10 хоногийн дотор ОЗШШБ болон ИНЕГ-т дараах хэлбэрээр ирүүлнэ:

- (1) СА005 маягтаар; эсхүл
- (2) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан дэлгэрэнгүй нь тухайн осол гарсан цаг үед агаарын хөлөгт байсан нисэх багийн гишүүн бүрийн тухайн осолтой холбоотой баримт, бодит нөхцөл байдлыг дэлгэрэнгүй дурьдсан тайлбарыг агуулна.

(с) Хэрэв нисэх багийн гишүүн эрүүл мэндийн улмаас энэ зүйлийн (б)-д шаардсан тайлбарыг гаргаж өгөх боломжгүй бол, боломжтой болсон даруйд нөхөн гаргана.

12.55. Зөрчлийг мэдэгдэх

(а) Хууль болон дараах Дүрмийн дагуу Даргаас олгосон гэрчилгээ эзэмшигч нь хэрэв агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчилд, эсхүл ноцтой зөрчилд өртсөн бол, аливаа холбогдох зөрчлийг ОЗШШБ болон ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй:

- (1) ИНД-115, 119, 129 болон 137 - агаарын хөлгийн зөрчил, эсхүл аюултай барааны зөрчлийг;
- (2) ИНД-172 - агаарын зайн зөрчлийг;
- (3) ИНД-171, 174 - байгууламжийн алдааны зөрчлийг;
- (4) ИНД-47, 115, 119, 129, 137, 145, 146 болон 148 - гэмтлийн зөрчлийг;
- (5) ИНД-119, 129, 139, 140, 171 болон 172 - аюулгүйн хамгаалалтын зөрчлийг;
- (6) ИНД-139 - аэродромын зөрчлийг;
- (7) ИНД-139, 171, 173, 174 болон 175 - түгээгдсэн мэдээллийн зөрчлийг;
- (8) ИНД-119, 129 болон 109 - ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг.

(b) Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчилд, эсхүл ноцтой зөрчилд өртсөн этгээд нь тухайн зөрчлийн талаар ОЗШШБ болон ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй, хэрэв тухайн этгээд нь:

- (1) агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нисэхтэй холбоотой үйлчилгээний хувьд үйл ажиллагаа эрхэлдэг, техник үйлчилгээ хийдэг, үйлчилгээ үзүүлдэг, эсхүл аливаа бусад хэлбэрээр оролцдог бол;
- (2) энэ зүйлийн (a)-д дурьдсан гэрчилгээ эзэмшигчийн ажилтан биш, эсхүл түүнд хамааралгүй бол; эсхүл
- (3) ИНД-95-ийн дагуу хариуцлага хүлээсэн бол.

(c) Хэрэв агаарын зайн, эсхүл шувуутай холбоотой зөрчил нь ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил бол, агаарын хөлгийн дарга тухайн зөрчлийн талаар ОЗШШБ болон ИНЕГ-т цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (a), (b), (c) болон (d)-д шаардсан зөрчлийн талаарх мэдэгдэл нь тодруулах боломжтой мэдээллийг агуулсан байх ба дараах хавсралтад заасны дагуу ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр ирүүлэх үүрэгтэй:

- (1) агаарын зайн зөрчлийн хувьд, Хавсралт А(a);
- (2) гэмтлийн зөрчлийн хувьд, Хавсралт А(b);
- (3) байгууламжийн алдааны зөрчлийн хувьд, Хавсралт А(c);
- (4) агаарын хөлгийн зөрчлийн хувьд, Хавсралт А(d);
- (5) аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт А(e);
- (6) түгээгдсэн мэдээллийн зөрчлийн хувьд, Хавсралт А(f);
- (7) аэродромын зөрчлийн хувьд, Хавсралт А(g);
- (8) ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт А(h);
- (9) аюултай барааны зөрчил, шувуутай холбоотой зөрчил, эсхүл аливаа бусад зөрчлийн хувьд, Хавсралт А(i).

(e) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан:

- (1) хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, хэрэв тухайн зөрчил нь EDTO нислэгт ашиглаж буй, эсхүл ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой гарсан бөгөөд тухайн зөрчилд дараах нөхцөл байдал холбоотой бол, зөрчил гарснаас хойш 72 цагийн дотор зөрчлийн талаар ОЗШШБ болон ИНЕГ-т мэдэгдэх үүрэгтэй:
 - (i) татах хүчний төхөөрөмж агаарт унтрах; эсхүл
 - (ii) даялах (diversion), эсхүл эргэж буцах (a turn back) үед; эсхүл
 - (iii) нислэгт гэнэт түлш алдагдах, эсхүл түлшгүй болох, эсхүл залруулах боломжгүйгээр түлшний тэнцвэр алдагдах; эсхүл
 - (iv) EDTO нислэгт нөлөө бүхий системийн алдаа; эсхүл
 - (v) EDTO нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад хэрэг явдал;

- (2) ИНД-145-ийн дагуу олгосон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь EDTO нислэгт ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой дараах зөрчил илэрснээс хойш 72 цагийн дотор ИНЕГ-т мэдэгдэх үүрэгтэй:
- (i) EDTO нислэгт нөлөө бүхий системийн алдаа; эсхүл
 - (ii) EDTO нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад гэмтэл.

12.57. Зөрчлийн дэлгэрэнгүй

(a) Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил, эсхүл ноцтой зөрчлийн талаар 12.55-д заасны дагуу мэдэгдсэнийг үл харгалзан, зөрчилтэй холбоотой дараах этгээд нь холбогдох зөрчлийн дэлгэрэнгүйг (b)(1), эсхүл (b)(2)-т заасан холбогдох маягтад шаардсан мэдээллийн дагуу ОЗШШБ болон ИНЕГ-т ирүүлэх үүрэгтэй:

- (1) 12.55 (a)-д дурьдсан гэрчилгээ эзэмшигч;
- (2) 12.55 (b)-д дурьдсан этгээд;
- (3) 12.55 (c)-д дурьдсан хөлгийн дарга.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан этгээд нь зөрчлийн дэлгэрэнгүйг зөрчил гарснаас хойш 14 хоногийн дотор ОЗШШБ болон ИНЕГ-т дараах хэлбэрээр ирүүлэх үүрэгтэй:

- (1) CA005 маягтаар; эсхүл
- (2) гэмтлийн зөрчлийг CA005D маягтаар; эсхүл
- (3) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр.

12.59. Шинжлэн шалгах, тайлагнах

Энэ дүрмийн 12.57-д заасны дагуу ОЗШШБ болон ИНЕГ-т зөрчлийн дэлгэрэнгүйг ирүүлэх шаардлагатай 12.55(a)-д дурьдсан гэрчилгээ эзэмшигч нь, ОЗШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, дараах үүрэгтэй:

- (1) тухайн зөрчилд, түүнтэй холбоотой баримтыг таньж тогтоох шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэх, эдгээр баримтыг бүрэн гүйцэд ашиглан, тухайн зөрчлийн шалтгаан, эсхүл шалтгаануудыг тогтоох;
- (2) тухайн зөрчил гарснаас хойш 90 хоногийн дотор шинжлэн шалгах ажиллагааг дуусган, тухайн шинжлэн шалгах ажиллагааны тайланг ОЗШШБ болон ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлэх:
 - (i) CA005 маягтаар; эсхүл
 - (ii) гэмтлийн зөрчлийг CA005D маягтаар; эсхүл
 - (iii) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр;
- (3) ижил төстэй зөрчил давтагдахаас сэргийлэх зорилгоор, аливаа авсан арга хэмжээний талаар ОЗШШБ болон ИНЕГ-т мэдээлэх.

12.61. Мэдээлэл хүргүүлсэн этгээдийг нууцлах

Энэ дүрмийн 12.55, эсхүл 12.57-д заасны дагуу мэдээлэл хүргүүлсэн этгээд нь нууцлахыг хүссэн тохиолдолд тухайн ОЗШШБ болон ИНЕГ нь:

- (1) тухайн эх үүсвэрийг таньж тогтоож болох аливаа мэдээллийг цаг алдалгүй арилгана;
- (2) энэ хэсгийн (1)-ийн дагуу арилгасан мэдээллийн аливаа өөр бүртгэл хөтлөхгүй.

12.63. Шийтгэлээс ангид байх

ОЗШШБ болон ИНЕГ нь дараахаас бусад тохиолдолд, этгээдийн энэ дүрмийн дагуу өгсөн мэдээллийг гэм буруутныг тогтоох зорилготой мөрдөн байцаах, эсхүл шүүхийн ажиллагаанд ашиглахгүй, эсхүл ашиглах боломж олгохгүй:

- (1) тухайн мэдээлэл нь аливаа этгээд, эсхүл өмч хөрөнгөд шаардлагагүйгээр аюул учруулсан үйлдэл, эсхүл эс үйлдлийг илчилсэн; эсхүл
- (2) хуурамч мэдээлэл хүргүүлсэн; эсхүл
- (3) ОЗШШБ болон ИНЕГ нь мэдээллийг хуулийн дагуу, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гаргаж өгөх үүрэг хүлээсэн бол.

С Бүлэг — Агаарын хөлөг, түүнд агуулагдсан эд зүйлс болон бүртгэлийг битүүмжлэх**12.101. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх**

(a) Хууль болон энэ зүйлийн (b), (c)-д зааснаас бусад тохиолдолд, ОЗШШБ-аас тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрөөгүй бол, аливаа этгээд осолд өртсөн агаарын хөлөг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, хөндлөнгөөс оролцох, эсхүл салгаж авахыг хориглоно.

(b) Хуульд заасан хязгаарлалтыг харгалзан, ОЗШШБ нь шинжлэн шалгах зорилгоор, осолд өртсөн агаарын хөлөг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, үзлэг хийх, хамгаалах, битүүмжлэх, эсхүл салгаж авч болно.

(c) Этгээд нь энэ зүйлийн (d)-г харгалзан:

- (1) хүмүүс, эсхүл мал амьтныг тухайн агаарын хөлөг, эсхүл эвдэрхий хэсгийн дотроос гаргах; эсхүл
- (2) агаарын хөлөг, эвдэрхий хэсэг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлс, эсхүл шууданг цаашдын гэмтлээс хамгаалах; эсхүл
- (3) бүхээгийн дуу чимээ бичигч, нислэгийн өгөгдөхүүн бичигч, эсхүл ослын байрлал дамжуулагчийг унтраах, эсхүл салгах; эсхүл
- (4) боломжит өөр арга зам байхгүй бол, олон нийтэд, эсхүл нислэгийн хөдөлгөөнд саад учруулахаас сэргийлэх.

(d) Энэ зүйлийн (c)-д заасны дагуу салгаж авсан агаарын хөлгийн аливаа эвдэрхий хэсэг, шуудан, эсхүл ачааг:

- (1) зөвхөн аюулгүй байдлыг бататгахад хэрэгтэй зайд шилжүүлсэн байна;
- (2) тухайн агаарын хөлгийн аль хэсгээс авсныг үзүүлэх боломжтойгоор тусад нь ялгаж хадгалсан байна;
- (3) боломжтой бүх тохиолдолд, тэдгээрийн анхны байрлал, мөргөлтийн чухал ул мөрийг гэрэл зураг, гар зураг, эсхүл тэмдэглэлээр баримтжуулсан байна.

12.103. Бүртгэлийг битүүмжлэх

(a) Ноцтой зөрчил, эсхүл осолд өртсөн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа, техник үйлчилгээтэй холбоотой бүх мэдээллийг агуулж байгаа мэдээлэл зөөгчийг багтаасан бүх бүртгэлийг ОЗШШБ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, осол, эсхүл ноцтой зөрчил гарснаас хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

(b) Дараах дүрмийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) ИНД-171 - байгууламжийн алдааны зөрчилд, эсхүл осолд; эсхүл
- (2) ИНД-172 - агаарын зайн зөрчилд, эсхүл осолд; эсхүл
- (3) ИНД-173, ИНД-175 - түгээгдсэн мэдээллийн зөрчилд, эсхүл осолд;

холбогдвол тухайн осол, эсхүл зөрчилтэй холбоотой бүртгэлд оруулсан бичилтүүд, цахим бичлэгүүд, техникийн болон холбогдох бусад өгөгдөхүүнийг багтаасан бүх бүртгэлийг ОЗШШБ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, тухайн осол, эсхүл зөрчлөөс хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

(c) Түгээгдсэн мэдээллийн осол, эсхүл зөрчилд холбоотой, ИНД-95-ийн дагуу хариуцлага хүлээсэн этгээд нь бүртгэлд оруулсан бичилт, цахим бичлэг, техникийн болон холбогдох бусад өгөгдөхүүнийг багтаасан бүх бүртгэлийг ОЗШШБ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, тухайн осол, эсхүл зөрчлөөс хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

12.105. Гэмтэлтэй бүтээгдэхүүн, бүрдэл хэсгийг хадгалах

Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч болон 12.59 (2)-ын дагуу гэмтлийн зөрчлийн талаар ОЗШШБ болон ИНЕГ-т мэдээлэх үүрэгтэй ИНД-145, ИНД-146, эсхүл ИНД-148-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь гэмтлийн зөрчилтэй холбоотой бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийг ОЗШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, тухайн мэдээлэл өгснөөс хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

D Бүлэг — Статистик мэдээ

12.151. Агаарын хөлгийн үйл ажиллагааны статистик мэдээ

(a) Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа эрхлээгүй глайдераас бусад, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь Хүснэгт 1-т заасан статистик өгөгдөхүүн болон мэдээллийг агаарын хөлөг тус бүрээр, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагааны тайланг Хүснэгт 2-т заасан тогтоосон болон дуусах хугацаанд, хөлс, эсхүл шан урамшуулалгүй үйл ажиллагааны тайланг Хүснэгт 3-т заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг дараах байдлаар хүргүүлэх үүрэгтэй:

(1) САА605 маягтаар; эсхүл

(2) цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр.

(c) Агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч нь, Хүснэгт 2, эсхүл Хүснэгт 3-т заасан мэдээлэх хугацаанд тухайн агаарын хөлөг нислэг үйлдээгүй байсан ч агаарын хөлгийн үйл ажиллагааны статистик мэдээг үргэлжлүүлэн өгөх үүрэгтэй.

Хүснэгт 1. Агаарын хөлгийн үйл ажиллагааны төрөл бүрээр шаардлагатай статистик өгөгдөхүүн, мэдээлэл

Агаарын хөлгийн үйл ажиллагаа	Статистик өгөгдөхүүн, мэдээлэл
Гадаад улсад агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг • Зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн нийт ачааны жин
Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг • Хоёр өөр аэродромын хооронд зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Завсрын буултгүйгээр, нэг аэродромоос эхэлж тухайн аэродромдоо дууссан, зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн нийт ачааны жин
Монгол Улсаас болон Монгол Улсад зөвхөн ачаа тээврийн нислэг үйлдсэн Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн тэмдэглэгээ • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн нийт ачааны жин
Шүхрийн үйл ажиллагаанаас бусад, Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар, эсхүл ИНД-47-ийн дагуу бүртгэх шаардлагагүй агаарын хөлгийн хувьд таних тэмдэг • Ниссэн цаг • Зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо

Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа шүхэр	<ul style="list-style-type: none"> • Шүхрийн таних тэмдэг • Тандем шүхрийн буултын тоо
Дээр зааснаас бусад, нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг Монгол Улсын бүртгэлтэй стандарт, эсхүл хязгаарлагдмал категорийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг

Хүснэгт 2. Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд ашигласан агаарын хөлгийн тайланг мэдээлэх хугацаа

Тайлан	Хамарсан хугацаа	Эцсийн хугацаа
1-р улирал	01 сарын 01-ээс 03 сарын 31	05 сарын 01
2-р улирал	04 сарын 01-ээс 06 сарын 30	08 сарын 01
3-р улирал	07 сарын 01-ээс 09 сарын 30	11 сарын 01
4-р улирал	10 сарын 01-ээс 12 сарын 31	02 сарын 01

Хүснэгт 3. Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа эрхэлдэггүй агаарын хөлгийн тайланг мэдээлэх хугацаа

Тайлан	Хамарсан хугацаа	Эцсийн хугацаа
Жилийн	01 сарын 01-ээс 12 сарын 31	02 сарын 01

12.153. Статистикийн тайлангийн нууцлал

(а) ИНЕГ, эсхүл ИНЕГ-ын аливаа ажилтан нь дараахаас бусад тохиолдолд, аливаа агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхойлсон, статистик тайланд орсон аливаа мэдээллийг ИНЕГ-аас гадагш аливаа этгээдэд дамжуулахыг хориглоно:

- (1) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлтэйгээр; эсхүл
- (2) Чикагогийн конвенцийн 67 дугаар зүйлийн дагуу; эсхүл
- (3) эрх зүйн баримт бичгээр шаардсаны дагуу.

(б) ИНЕГ нь олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлд гаргаж өгч болно.

Хавсралт А — Зөрчлийн анхны мэдэгдэлд шаардагдах мэдээлэл

(а) **Агаарын зайн зөрчил** – 12.55 (d)(1)-д заасны дагуу агаарын зайн зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар болон төрөл;
- (4) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил болон өндөр;
- (6) тухайн хөлгийн даргын нэр;
- (7) нислэгийн үе шат;
- (8) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (9) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа явуулж байсан нислэгийн дүрэм;
- (10) агаарын хөлгийн нисэн гарсан болон хүрэх цэг;
- (11) байрлал, маяг болон агаарын зайн ангилал, оролцсон НХҮ-ний нэгж;
- (12) тухайн холбогдох нисгэгчийн өгсөн бусад хамааралтай мэдээлэл.

(б) **Гэмтлийн зөрчил** – 12.55 (d)(2)-д заасны дагуу гэмтлийн зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчил илэрсэн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл болон маяг;
- (4) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон эзэмшигчийн нэр;
- (5) тухайн зөрчил гарсан үед агаарын хөлөг, эд анги, эсхүл тоног төхөөрөмж байсан байрлал;
- (6) нислэгийн үе шат;
- (7) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (8) агаарын хөлөг нисэн гарсан болон хүрэх цэг;
- (9) агаарын хөлөг, эд анги, эсхүл тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн нэр, боломжтой бол эд ангийн дугаар, түүний модификацийн стандарт болон агаарын хөлөг дэх байрлал;
- (10) тухайн зөрчлийн тайлбар, түүний нөлөө болон бусад хамааралтай мэдээлэл;
- (11) мэдэгдэл хийсэн этгээд, эсхүл байгууллага тухайн гэмтлийг шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлсэн бол дуусгахаар төлөвлөсөн хугацаа;
- (12) тухайн зөрчлийг мэдээлэсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(с) **Байгууламжийн алдааны зөрчил** - 12.55 (d)(3)-д заасны дагуу байгууламжийн алдааны зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар, маяг;
- (4) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил, өндөр;
- (6) аэродромын нэр, ашигласан ХБЗ;
- (7) тухайн хөлгийн даргын нэр;
- (8) нислэгийн үе шат;
- (9) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (10) холбогдох навигацийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэгчийн нэр, тоног төхөөрөмжийн нэр, төрөл, давтамж, таних тэмдэг;
- (11) мэдэгдэл хийсэн этгээд, эсхүл байгууллага зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлсэн бол дуусгахаар төлөвлөсөн хугацаа;
- (12) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(d) **Агаарын хөлгийн зөрчил** - 12.55 (d)(4)-д заасны дагуу агаарын хөлгийн зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар, маяг;
- (4) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон эзэмшигчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил, өндөр;
- (6) нислэгийн үе шат;
- (7) хамааралтай бол, аэродромын нэр болон ашигласан ХБЗ;
- (8) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (9) тухайн хөлгийн даргын нэр;
- (10) гүйцэтгэж байсан үйл ажиллагааны төрөл;
- (11) тухайн агаарын хөлгийн бүхээг дэх хүмүүсийн тоо;
- (12) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(e) **Аюулгүйн хамгаалалтын зөрчил** - 12.55 (d)(5)-д заасны дагуу аюулгүйн хамгаалалтын зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар, маяг;
- (4) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон эзэмшигчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил болон өндөр;
- (6) хэрэв хамааралтай бол, аэродромын, эсхүл нисэхийн холбооны байгууламжийн нэр;
- (7) тухайн хөлгийн даргын нэр;
- (8) нислэгийн үе шат;
- (9) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (10) гүйцэтгэж байсан үйл ажиллагааны төрөл;
- (11) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(f) **Түгээгдсэн мэдээллийн зөрчил** – 12.55 (d)(6)-д заасны дагуу түгээгдсэн мэдээллийн зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийг илрүүлсэн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) хэвлэл, газрын зураг, схем зураг, эсхүл бусад хэлбэрээр түгээгдсэн тухайн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөхүүнийг таньж тогтоох дэлгэрэнгүй;
- (4) тухайн зөрчилд хүргэсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөхүүнтэй холбоотой дэлгэрэнгүй;
- (5) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(g) **Аэродромын зөрчил** - 12.55 (d)(7)-д заасны дагуу аэродромын зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) тухайн аэродромын нэр;
- (4) тухайн мэдээлэгдсэн гэмтэл, эсхүл саадын тодорхойлолт болон байрлал;
- (5) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

(h) **Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил** - 12.55 (d)(8)-д заасны дагуу ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:

- (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
- (2) тухайн зөрчлийн шинж байдлын товч тайлбар;

- (3) хэрэв мэдэгдэж байгаа бол, тухайн зөрчил гарсан байж болох газрын дэлгэрэнгүй;
- (4) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.
- (i) **Аюултай барааны, шувуутай холбоотой, эсхүл бусад зөрчил** - 12.55 (d)(9)-д заасны дагуу аюултай барааны, шувуутай холбоотой, эсхүл аливаа бусад зөрчлийн мэдэгдэлд дараах мэдээллийг шаардана:
 - (1) тухайн зөрчлийн огноо, цаг;
 - (2) үйл явдлын товч тайлбар;
 - (3) тухайн зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих дэлгэрэнгүй.

--oOo--